МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 27 өдөр　　Дугаар А/383　　Есөнбулаг сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам" А/254 дүгээр тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар "Аймгийн 2025 оны төсвийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх "Хөгжил хорооллын халаалтын эх үүсвэрт холболт хийх" ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Д.Чинзориг | (Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| Гишүүд: | З.Жаргалтуяа | (Аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн) |
| | Ц.Зоригт | (Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл) (тохиролцсоноор) |
| | Б.Доржпалам | (Иргэний төлөөлөл) (тохиролцсоноор) |
| Нарийн бичиг | Н.Алгирмаа | (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн) |

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай, шуурхай зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг үнэлгээний хороо (Д.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА　　Г.ЧИНБАТ

D:Ajil, zahiramj Zax ZD 2025
8200081071

8200010628